



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/306

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийх, байнгын ашиглалтанд хүлээж авах зэрэг ажилд ашиглагддаг аймгийн Засаг даргын Тамгын газрын 0003 ХОА улсын дугаартай, Ланд круйзер 200, 0016ХОЕ улсын дугаартай Лексус 470 маркийн тээврийн хэрэгслүүдийн засвар үйлчилгээний зардалд 8 303 150 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 8 303 150 төгрөг /Найман сая гурван зуун гурван мянга нэг зуун тавин/-ийг Хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал / нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
06 дугаар сарын 17-ны өдрийн
А/306 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 0003ХОА УЛСЫН ДУГААРТАЙ,
ЛАНД КРУЙЗЕР 200, 0016ХОЕ УЛСЫН ДУГААРТАЙ ЛЕКСУС 470 МАРКИЙН
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮДИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛД ТӨСӨВ

Д.д	Засвар үйлчилгээний зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ-НӨАТ-тэй /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	0016 ХОА Лексус-470	ком	1	4 535 700	4 535 700
2.	0003 ХОА Ланд-200	ком	1	3 767 400	3 767 400
ДҮН					8 303 150

-oOo-